

## Нэр байгаа л бол заавал „юм“ бий

Л.Дашням

### Бяцхан өлгөц

Хэлсудлал нь харьцангуй эртний шинжлэх ухаан боловч эдүгээ өөрийн судлагдахууны чинад хүрч, бүхнийг нэг мөр болгочихжээ гэж үзэх учир үгүй. Газар газрын олон эрдэмтэн, судлаачид хэлийг нийгмийн хөгжлийн буюу нийгэмшлийн үр дүн гэдэг нийтлэг нэгэн оношлолд хүрсэн хэдий ч чухамдаа хэл бол байгалийн „бүтээгдэхүүн“ гэдэгтэй ч санаа оноо нийлэгчид нэмэгдсээр л байгаа юм. Аливаа хэлний хөгжиж өөрчлөгдөж, “мөнхийн хөдөлгөөнд” оршдог шинж чанар, шинэ шинэ үг, ойлголт ухагдахуунаар баяжиж, илэрхийлэх чадвар нь ямагт өсөн нэмэгдэж, гүнзгийрч байдаг нь нийгэмжлийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хуулийн дагуу болж бүтэж байгаа явдал - үйл гэхээсээ илүү байгалийн эрхээр, оршин тогтнохуйн хуулиар явагдаж буй үйл явц гэж ойлгох нь зүйд илүү нийцмээр санагддаг. Уранбүтээлчид, сэтгэгчид, мэргэжлийн хүмүүс тэр байтугаа хүүхэд багачууд ч хэлний хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг нь үнэн.

Хэлний тухай, ялангуяа түүний хөгжил, нийгмийн амьдралд нөлөөлсөн үүрэг оролцооных нь тухай онцгойлон өгүүлсэн нь бишгүй олон. Хэдий тийм ч хэлний танин мэдэхүүд нөлөөлсөн гайхамшигт чадвар, бүтээгч хүчин болох аугаа “авъяасынх” нь тухайд ярих зүйл дуусаагүй л байгаа гэж бодном.

Хэл бол танин мэдэхүйн төвшинг илэрхийлэгч онцгой “увидас” мөн. Тийм ч учраас түүнийг нийгмийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлүүдийн нэг ч гэж үзэж болно. Хүн төрөлхтөний хөгжилд нэмэрлэсэн хэлний ач тус нь бусад ямар ч хүчин зүйлээс дутахааргүй арвин. Дэлхийн аль ч өнцөг булан бүрт бий болсон хэлний ололт, хөгжил нь нөгөө нэг хэлдээ нөлөөлдөг бөгөөд хэлний хөгжил түгээмэл зүйтогтолтой гэж ойлгогддог. Хүмүүс өөрсдийн эргэн тойронд байгаа, хүрч өртөж байгаа, оролцож оролдож байгаа бүхий л зүйлээ танин ойлгож, түүндээ ямар нэг ухагдахуун, нэр хаяг оноодог. Өөрөөр хэлбэл тэрхүү “судлагдахуунаа” тухайн цаг үеийнхээ ойлголтоор томъёолж тодорхойлдог гэсэн үг юм. Хамгийн наад зах нь монгол хүн өөрийн эргэн тойронд байгаа уул ус, мод хад, бүхий л зүйлийг танин ойлгосны хэрээр нэр зүс оноож ирсэн шигээ хөндий хоосон бүхнийг дүүргэж буй зүйлийг ч ойлгон ухаарч **а-гаар** (анхдагч эхлэл хий) гэж нэрлэсэн байдаг шүү дээ. Тэгээд тэрхүү ойлголт ухаарал нь салбарлан лавширч **у-гаар** (утаат хий) (**а**)гаарах (дэврэх, хөөрөх, хийрхэх) гэх мэтчилэн олон олон ойлголт бүтээж, нэр оноосон. Оросууд ч мөн адил **воздух** (хөөрөгч “санаа”), **воздыхать** (амьсгаалах, амьсгаадах) **вздох** (амьсгаа авах, санаа алдах), **одышка** (амьсгаа давхцах) гэх мэт үгсийг төрүүлсэн бол латин хэлтнүүд **аеро, air** гэдэг үг бүтээсэн нь мөн л хий гэсэн утгатай бөгөөд манай агаартай “агаар нэг” үг ч байж болзошгүй юм.

Ийнхүү хий хоосон оронг олон хэлд өөр өөрийнхөөрөө боловч цөм л нэгэн утгатайгаар илэрхийлж тэрхүү “хий”-ний утга агуулга улам нарийсч, агаар гэдэг нь хоосон орон зай ч биш, тэр байтугаа дан ганц хий ч биш, бүр олон олон хийн хуримтлал болох нь танигдсан байна. Танин мэдэхүй ингэж гүнзгийрч салбарлан, тэр бүхэнд шинэ ухагдахуун, шинэ нэр бий болдог бөгөөд хэн эхэлж нэрлэсэнээр нь уламжлан хэрэглэх буюу эсвэл өөр өөрийн хэлний боломж,

нөөцийг нээн, тухайн ойлголтыг өөрийн болгодог уламжлалтай болжээ. Жишээ нь: Хөлөөрөө биш дугуйгаар явдаг нэгэн унаа бүтээснээ "эзэд" нь **mashine** гэж нэрлэснийг хожим хойно аль газрын хэнбугай ч мөн л **mashine** (машин) гэж ухаарч, тийн нэрлэсээр ирсэн нь түүхэн баримт юм.

Хэл бүтээлч шинжтэй. Түүний хөгжилд онцгой авъяас билигт хүмүүс, ялангуяа оюунлаг, сэрэл, сэтгэхүйн мэдрэмж сайтай, хэлийг бүтээлчээр хэрэглэгчид онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг. Нэг үгээр, хэлийг бүтээгчдийн ачаар түүхэн урт удаан хугацаанд хэл маань улам чадварлаг, улам уран тансаг, гүн нарийн илэрхийлэлтэй, бүхэнд нэвчих, бүхнийг "оношлох" чадвар бүхий болжээ гэж үзэж болно.

Хэлийг хөтөлж, чирч хөгжүүлдэг хөшүүрэг нь зөвхөн нийгмийн шаардлага ч биш юм. Хүмүүний өөрийгөө болон бусдыг таньж олох, илэрхийлэх тэмүүлэл, сонирхон шохоорхогч зан, "мөнхийн" эрэл хайгуул л чухамдаа хэлийг хөгжүүлдэг гэж хэлж болно.

Монголчууд бид ч бусад олон ард түмний нэгэн адил төрөлх хэлээ урт удаан хугацаанд хөгжүүлж ирсэн бөгөөд монгол хэлний хөгжилд бидний хүрээлэн буй орчин, түүхэн амьдрал, соёлын хүрээ, дотоод гадаадын олон харилцаа холбоо ихээхэн нөлөөлсөн нь ойлгомжтой.

Монгол хэл бол хамгийн баян тансаг, гайхамшигтай илэрхийлэх чадвартай хэл гэж баттайяа хэлж болно. Үүнд монгол хэлний үүсэж хөгжсөн бүхий л түүхэн замнал нөлөөлсөн нь лав.

Тухайлбал: манайхны *зүйр цэцэн үг* гэж ерөнхийлөн нэрлэдэг монгол хэлний үгсийн сангийн хамгийн нарийн нандин хэсгийг ажиглахад л олон зүйл ярьж болмоор байдаг. Тийм үг хэллэг зөвхөн монгол хэлд ч байдаг биш, бусад олон хэлд ихээхэн түгээмэл байдаг бөгөөд тэдгээр нь амьдрал, ахуйн өргөн ойлголтыг шингээсэн ухахуйяа бахтай, томъёолол илэрхийлэл гүн нягт, ард түмнүүдийн оюун ухаарлын охь болсон "бүтээгдэхүүн" юм. Зөвхөн *зүйр, цэцэн үгс* ч биш, өөр агуулга, хэлбэрээр илэрхийлэгдсэн *билгүүн үг* ч олон байдаг. Тийм үгс хөгжлийнхөө явцад утга илэрхийлэл нь улам бүр нарийсч олон олон нэр хаягтай болсон нь ч ойлгогддог. Миний бодлоор, тэдгээр үгсийг нэг хэсгийнх нь төлөөллөөр *зүйр цэцэн үгс* гэх биш ерөнхийд нь *билгүүн үгс* гэж нэрлээд, дотор нь нарийвчлан ялгаж салгах хэрэгтэй бөгөөд тэгж чадваас "хэрэглээний" учир утга нь нарийсч гүнзгийрэхээр үл барам, ойлголт ухаарлын ч чухал ач холбогдолтой болох нь дамжиггүй юм.

"*Билгүүн үгс*"-ийг утга агуулгаар нь юмуу өгүүлэмж илэрхийллийнх нь хувьд ангилж зиндаалахад тулгарч буй гол бэрхшээл нь юуны өмнө түүхэн урт удаан хугацаанд хуримтлагдан бий болсон тэдгээр үгсийн сан хөмрөг арвин их, хэрэглээний явцад баяжиж өөрчлөгдөж байдаг "хөдөлгөөнт чанар"-тайгаас гадна судлаачаас хэлний мэдлэгийн, ялангуяа утгазүй, бэлгэдэлзүй, ёгтлол, уран өгүүлэмжийн нарийн ширийн ойлголт мэдрэмж шаарддаг л байгаа болов уу. Тийм ч учраас ав завд бүтчих, хэн хүнгүй бариад авчих ажил биш байдаг байж болно.

Орос хэлний *пословица, поговорка, изречения, афоризмы* зэрэг нь *умные слова, крылатые слова, меткие слова* зэрэг ерөнхий нэр зүүн, гол нь хэрэглээний утга агуулгаараа ялгагдаж ирсэн байхад англи хэлний *saying, proverb, aphorism* мэт нь *axiom, maxim, adage, by-word, saw* зэрэгтэйгээ хутгалдсан байх жишээтэй. Тэр байтугай *motto, slogan, truism, apigram, apothegm* зэрэгтэйгээ ч нийлээд явчихсан байх нь нэлээд өргөн тохиолдож байна.

Хэдийгээр амьдрал дээр байдал иймэрхүү байгаа ч "үг байвал утга буй" гэдэг зарчмаар шүүн тунгааваас тухайн нэрийг зүүж буй үг, илэрхийлэл бүр өөрийн нэг тусгайлсан "чадвартай" болох нь танигдаж байгаа юм. Үнэхээр ч, юм байгаа цагт л нэр, ойлголт бий болж, бас ойлголт ухагдахуун нь оносон нэрээ нэхдэг байна.

Юутай ч, өөрийн хэлний болон өөр бусад хэлний "*билгүүн үгс*"-ийн сав айд багтаж байгаа үгсийн илэрхийлэл, утга агуулга, хэрэглээний ялгарлыг харьцуулан болгоож, нягтлан үзвээс одоо цагийн ойлголт ухаарлын төвшинд ямар нэг ангилал хийх боломж байх шиг санагдсан учир хойно ирээдүйд энэ "ачааг үүрэх" эрдэм ном, эрэл сурлын хүмүүст бяцхан өдөөлгө болгох зорилгоор анхны өчүүхэн оролдлогыг хийж байна.

Монгол хэлний билгүүн үгсийг юуны өмнө зүйр үг, цэцэн үг гэж ангилах бүрэн боломжтой бөгөөд ер нь цэцэн цэлмэг үгсийн ай савд багтаж буй бүх үг, илэрхийллийг бусад хэлний энэ салбарт хамаарах үгс, ойлголттой дүйцүүлээд, *мэргэн үг, онч үг, гарьд үг, олиг үг, сургаал үг* гэх мэтээр ангилж зааглаж болмоор байгаа юм. *Зүйр цэцэн үгсийн* дотор *цольд үгс, хэвшмэл хэллэг, хэлц үгсийн* хэлбэр, агуулга, илэрхийллийг шингээсэн үгс ч мөн цөөнгүй байх бололтой.

Юутай ч, миний оролдлого, энд дэвшүүлж буй саналыг мэргэд цааш нягтлан, хэрэгтэй тустай гэж үзвээс хэвшүүлж, ойлголт ухаарлын „зэвсэг“ болгох боломж гарах болов уу гэж найдаж байна.

### 1. Зүйр үгс. Пословицы (Алетрированные слова). *Proverb.*

Нэгэн зүйлийг нөгөөтэй нь адилтгаж, жишиж давхар санаа сүлжээлэн шингээсэн, дийлэнхдээ мэдүүлэх, ухааруулах утга бүхий үгс.

*Аавын хүү адилгүй  
Арван хуруу тэгшгүй*

*Аарц уусан дотогшоо  
Архи уусан гадагшаа*

*Авах гэхэд  
Азарган дорго шиг  
Өгөх гэхэд  
Өмхий хүрэн шиг*

*Аж төрж амь зуух  
Алалдах дайсантай адил*

*Алмааз эрдэнэ зүлгэх тусам өнгө орж  
Аавын хүү явах тусам ухаан суудаг*

*Зуд болоход хэрээ таргална  
Зовлон болоход лам таргална*

*Зүйр үгийн* найруулгын хийгээд утга илэрхийллийн онцлог нь аль нэг зүйлээр дэвсгэрлэж, эсвэл түүнээс аванхайлан аливаа нэгнийг нөгөөтэй нь жиших, адилтгах зэргээр илүү "ойр дөхөмд" нь түшиглэн арай "цаад" танин мэдэхүйг "бүтээж" байгаад оршино. Ажиглаваас, зүйр үгийн найруулгын хэлбэр нь мэт, адил, шиг, гэх зэргээр жиших, адилтгахаас эхлээд зэрэгцүүлэх, эсрэгцүүлэх, логик холбоо үүтгэх хүртэл найруулгын олон "урлагийг" эзэмшин хөгжжээ гэмээр байна.

Манай эрдэмтэд, судлаачдын цомоглож эмхтгэсэн элдэв ном, товхимолд орсон монгол билгүүн үгсийн дотор зүйр үг зонхилдоггүй, харин өөр маягаар илэрхийлсэн үгс илүү олон тохиолдож байна. Энэ нь уран цэцэн, мэргэн, ухаалаг үгсийн бүтэж, бүрэлдэх түүхэн явц нь аливааг жишин ойлгуулах аргаас улам нарийсч уран илэрхийллийн олон аргыг хэрэглэх болсонтой холбоотой ч байж болох юм.

### 2. Цэцэн үгс. Поговорки. *Sayings*

Амьдралын явцад танин ойлгосон аливаа юмс, үзэгдлийн тухайд уран цэцэнээр өгүүлсэн үгс. *Цэцэн үгс* нь хэлбэрийн хувьд "тийм, ийм", "тиймгүй, иймгүй", "тэгж ингэж болно", "болохгүй", "тэгдэг ингэдэг" гэх мэтчилэн сүрхий "бардам өгүүлэмжтэй", мэдэмхийрсэн, цэцэрхсэн найруулгатай байгаа нь ажиглагддаг. Гэвч чухамдаа аливаа үзэгдлийн үнэн мөний нь таньсан тэрхүү "мэдэмхийрэлд" л *цэцэн үгийн* амь сүнс оршиж байна гэмээр байгаа юм.

*Буруу зөвийг ялгаж болдог  
Будилсан хүн сэхэж болдог*

*Дөрөө урт ч газар хүрдэггүй  
Дүү сайн ч ахад хүрдэггүй*

*Дэгжин өнгө хувирдаг  
Дэндүү эхнэр хагацдаг*

*Огторгуйн нар шингэдэг  
Оройн очир шилжирдэг  
Үггүй хүнд үг хол  
Үхсэн хүнд дэр хол*

*Цаг цагаараа байдаггүй  
Цахилдаг хөхөөрөө байдаггүй*

### 3. Мэргэн үгс. Мудрые слова. /умные слова/. *Intelligent (Clever) sayings*

Мэргэд, ном эрдмийн хүмүүсийн аливааг болгоож ухаарсан, танин мэдэхүйн утга агуулгыг шингээсэн үгс. Илэрхийлэл нь ихэнхдээ тайлбаргүй үнэн (аксиом) байдалтай байдаг.

*Авах хүнд нэг үг ч эрдэнэ  
Орхих хүнд мянган үг ч улиг*

*Бороо дээлэн дээр ус  
Дэлхий дээр тос*

*Дотуур мэхээр дов эргэх  
Гадуур мэхээр газар эргэх*

*Нэр нэг  
Алдар хоёр*

*Цувж явсан бараас  
Цуглаж суусан шаазгай дээр*

### 4. Онч үгс. Меткие слова. *Apt sayings.*

Нүдий нь олж, зохимжтой, тохирч нийцэхүйцээр илэрхийлсэн цэцэн цэлмэг үгс. Дийлэнх нь хүмүүн хоорондын харилцаа, ахуйн хүрээ, аж төрөхүйн утга учир, цараа хүрээг хамарсан шинжтэй байна.

*Багын бардам  
Будааны омог*

*Баянд баян нэмэр  
Будаанд цагаа нэмэр*

*Богдоос боол нь ухаантай  
Хаадаас харц нь ухаантай.*

*Зовлон үзээгүй хүн  
Жаргал мэдэхгүй*

*Хүн залуудаан  
Цэцэг зундаан*

### 5. Гарьд үгс. Крылатые слова. *By word. Pithy sayings (Epea pteroenta)*

Сэтгэгчид, оюунлаг хүмүүсийн бодож болгоосон, сэтгэсэн, бясалгасан өнгө аяс, утга агуулгатай, хүмүүс үг яриандаа эш, жишиг болгох дургай танин мэдэхүй, сургаалын ач тус

бүхий "жинтэй" үгс. Зарим тохиолдолд зохиогч нь тодорхой бус, улирч уламжилж ирсэн, түгээмэл, ардын хэмээн нэрлэгддэг үгс ч байдаг.

*Атга модонд хэрэгцээ олон  
Асралт хүнд нөхөр олон*

*Онъс түлхүүрийн хэлхээ нэг  
Олон үйлийн холбоо нэг*

*Сайн муу нийлж амьдрал болно  
Сайхан муухай нийлж Орчлон болно  
Юм болгон учиртай  
Учир болгон утгатай*

#### 6. Цольд үгс. Афоризмы. *Aphorisms*

Цэцэд, мэргэд, ном эрдмийн хүмүүсийн томъёолж өгүүлсэн цомхон, ончтой, утга төгөлдөр үгс.

*Боол хүнд буруу тасрахгүй  
Борхон биенд сүүдэр тасрахгүй*

*Зандан мод залуургүй шулуун  
Заяатай хүн зааваргүй үнэнч*

*Өлсөөд идсэн чихэр  
Өтлөхөд төрсөн үр*

*Уулнаас салсан барс  
Уснаас салсан загас*

*Уусан ус рашаан  
Унасан газар алт*

#### 7. Сургаал үгс. Поучения, назидания. *Edifications*

Мэргэдийн сургаж соёсон, ухааруулж, анхааруулсан үгс.

*Аавын уурга барьж сур  
Адуу мал чинь өснө*

*Гадагш явах хүн  
Галаа манадаг*

*Нэр хугарахаар  
Яс хугар*

*Олны үг  
Оломгүй далай*

#### 8. Олиг үг. Притча. *Parable*.

Нийлэмж, нийцтэй байдал төрхийг ухааруулж ойлгуулсан, ёс зүйг номлосон үгс. Үүнийг өгүүлж, түүнийг ойлгуулан, гүн нарийн утга, давхар санааг агуулсан байдалтай байдаг.

*Аав ээжийн нүүр  
Ах дүүгийн завсар*

Аавд өгсөн юм  
Хүүд хүрдэг

Авах биш ааш  
Өгөх биш өнгө

Хоолой ноён  
Бие боол

Хүний уг нагац  
Модны уг үндэс

Хэлсэн үг мөнгө  
Хэлээгүй үг алт

9. **Хэлц үгс**. (Өвөрмөц хэллэг) Идиомы. *Idioms*.

Хэсэг бүлгийн хийгээд тодорхой хүрээнд ойлголцлын "хэрэгсэл" болж уламжлагдаж ирсэн бөгөөд улмаар хэрэглээний явцад нийтлэгжиж хэвшсэн, үгийн утгаар илэрхийлж буй санааг нь шууд тайлж ойлгохуйяа бэрх өвөрмөц илэрхийлэл бүхий үгс.

Булчин бурхан  
Хэрсэн чөтгөр

Дотор таг  
Толгойд яг

Нүүргүй дарга  
Нүдгүй толгой

Нэр нэдэр  
Чих зүдэр

10. **Хэвшмэл хэллэг**. Фразеология. *Phraseology*.

Үгийн үндсэн утга шилжрэн, тодорхой санаа, ойлголтыг илэрхийлэх шинэ "чадвартай" болж хэвшсэн, тогтвортой бүтэц бүрэлдэхүүнтэй үгс.

Нуур шиг шөл  
Нугас шиг мах

Нуглийн нүдийг  
Гурилаар хуурах

Нүүрзэн нуруундаа хийсэн  
Хүнээ хөлдөө чирсэн

Туулайн эвэр  
Тугалын соёо

Миний оролдож цөхсөн энэхүү өчүүхэн "санаачлагыг" мэргэд нягтлаж, шүүтгэн ариулах нь лав. Ер нь аливаа ангилал нь ойлголт ухаарлыг цэгцтэй болгохоос гадна танин мэдэхүйг хөгжүүлэх, ялангуяа аргачлалын чухал ач холбогдолтой байдаг тул байгаагийн эмх цэгцийг олох нь угаас судлаач бүхний гол зорилго, хийж оролдож ирсэн гол ажил нь гэж үзэлтэй.

Их санааг талбиад талбиад энэ бие, байгаа байдал минь нэг л болохоор эндэж осолдсон, буруу зөрүүг бодож сэтгэсэн нь бишгүй олон нь мэдээж. Учир иймийн утгыг ухах би бээр оролдлого эрмэлзлэлийг минь бадруулж баярлуулсан ч, унтрааж устгасан ч түмэнтэйеэ баярлахсан билээ. Энэ хорвоогийн зөв нь ч минийх, буруу нь ч минийх бөлгөө.